

Соёл ба тогтвортой хөгжил

Г. Батхуяг / Соёл, соёлын өвийн хэлтсийн дарга /

Нэгдсэн үндэстний гудамж 5/1

Засгийн газрын 2 –р байр 123 тоот

И-майл: Batkhuyag@culture.gov.mn

[Цахим хаяг: www.culture.gov.mn](http://www.culture.gov.mn)

2017.09.08








Соёл ба тогтвортой хөгжил

Агуулга

1. Соёл ба хөгжил
2. Монгол улсын хөгжлийн стратеги ба төрийн соёлын бодлого.
3. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Соёл ба тогтвортой хөгжил

Дэлхий дахинд ажил үйлдвэржсэн нийгмээс мэдлэгт тулгуурласан нийгэмд шилжих үйл явц эрчимтэй өрнөж энэхүү хөгжлийн шинэ орчин, нөхцөлд соёлын үүрэг шинэчлэгдэж, түүнийг **хүн төрөлхтөн, үндэстэн, угсаатны оршин тогтнол, аюулгүй байдал, хөгжил дэвшлийн баталгаа** хэмээн үзэх хандлага түгээмэл болжээ.



СОЁЛ БА ХӨГЖИЛ



Names 2008 2009 2010 2011 2012 2013 2014 2015

Мөн улс орнууд соёлыг “хөгжилтэй адилтган авч үзэж, эдийн засгийн гол нөөц, соёлын өвд суурилсан үйлдвэрлэл, аялал жуулчлал нь ашиг орлогын эх үүсвэрийг бий болгодог гэдгийг хүлээн зөвшөөрөх болсон.


Navigation controls on the right side of the slide, including a list of empty callout boxes and one box labeled "Хөгжил" with a left-pointing arrow.

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенц” 2005

Тус конвенц нь бүтээлч чанарыг эрчимжүүлэх, соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийг цаг алдалгүй хөгжүүлэх явдлыг дэмжиж байгаагаас гадна иргэдийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэгш оролцоог хангах, орон нутгийн үйлдвэрлэл, зах зээлийг хөгжүүлэх, улмаар дэлхийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, солилцоо хийх боломж арга замыг нээж өгч байгаа юм.


- Тус конвенц нь нийгэм, эдийн засгийн хүрээнд соёлын гүйцэтгэх үүрэг, ойлголт өөрчлөгдөж, соёл болон хөгжлийн хоорондын хамаарлыг чухалчилах болсныг дэлхий нийтэд зарласан.

- Мөн “Соёлыг хүн төрөлхтөний язгуур үнэт зүйл, улс үндэстний оршин тогтнохын нэг гол үндэс, тусгаар тогтнолын баталгаа болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, нийгэм, эдийн засгийн өсөлт, хөгжлийн нэг гол хэмжүүр нь соёлын хөгжил” гэдгийг тунхаглаж, соёлын хөгжлийг тэргүүн зэрэгт тавих уриалгыг гаргасан.




СОЁЛЫН ҮҮРЭГ


НИЙГМИЙН ОЮУН САНААНЫ ХӨГЖИЛ



НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ




Соёл зөвхөн нийгмийн оюун санааны хөгжлийг хангаад зогсохгүй нийгэм, эдийн засгийн өсөлтийг хангах нэг чухал хүчин зүйл болохыг дэлхий дахинаар хүлээн зөвшөөрөх болсон.



СОЁЛЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ



- i) Соёлын өвд суурилсан үйлдвэрлэлийг инновацийн чиг баримжаатайгаар хөгжүүлж, нутгийн иргэдийг ажлын байраар хангах байдлаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих,



СОЁЛЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ



-
-
-
- 5.Эдийн засаг
-
-
-
-
-
-

ii) нутгийн уламжлалт соёлын үнэт зүйлс, өв уламжлалыг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйл явц нь нутгийн иргэдийг бүтээлч үйл ажиллагаанд оролцох, хүн амын хүйсийн тэгш байдлыг хангах, өөрийгөө хүндэтгэх, илэрхийлэх боломжийг бүрдүүлэх.

ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, “МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030”



2012 онд Рио Де
Жанейро хотод болсон
НҮБ-ын чуулганы үеэр
анхлан санаачилсан

2015 оны 9-р сарын
25-нд


НҮБ-ын Ерөнхий
Ассамблейн
чуулганаар баталсан



2016 оны 2-р
сарын 6-нд УИХ-н
19 дүгээр
тогтоолоор
баталсан

Засгийн газрын 2016
оны 249 дүгээр
тогтоолоор ТХҮБ-н
журам батлагдсан

Богино болон
дунд хугацааны
бодлогыг ТХҮБ-
тай уялдуулах





ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Үе шат I: 2016-2020

Үе шат II: 2021-2025

Үе шат III: 2026-2030

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ – 14 чиглэл, 44 зорилт

Эдийн засгийн
тогтвортой
хөгжил

Нийгмийн
тогтвортой
хөгжил

Байгаль орчны
тогтвортой
хөгжил

Тогтвортой
хөгжлийн засаглал



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА

Монгол Улс 2030 онд:

- † нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээ хүрсэн,
- † тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай,
- † нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан,
- † экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан,
- † тогтвортой ардчилсан засаглалтай улс болно.







ДЭЛХИЙН
ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ЗОРИЛТУУД



Монгол Улсын
хөгжлийн үзэл
баримтлал

“МОНГОЛ УЛСЫН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 2030”

- Төрөөс баримтлах бодлого;
- Бүсчилсэн хөгжлийн бодлого;
- Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
- Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр

- БОГИНО 1жил**
- Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
 - Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
 - Энэ хуулийн 6.5.1-д заасан үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсөв



ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг доорх бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлнэ.





УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ын 4.1.8-д “соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, соёлын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, соёл, урлагийн зах зээлийг өргөжүүлэхэд салбар хоорондын уялдаа, холбоог сайжруулах”,

УИХ ын 2015 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 4.2.6.1-д “үндэсний түүх, өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, мэдлэг, мэдээлэлд суурилсан бүтээлч аж үйлдвэрийн салбарыг дэвшилтэт техник технологи, инновацид тулгуурлан мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар хөгжүүлж, шинэ чадавхи, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох” гэж, 4.2.6.2-т “соёлын статистикийг олон улсын байгууллагаас баталсан аргачлалын дагуу нэвтрүүлэх” гэж тус тус заасан.

УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ын Тав.Бусад зүйл

5.1.Соёлын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан соёл, урлагийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

5.2.Соёлын талаар баримтлах бодлогыг

- Засгийн газар,
- Төрийн захиргааны төв байгууллага
- Төрийн захиргааны байгууллага.
- Нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэгт хамааруулан,

•урт,

•дунд,

•богино хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

5.3.Соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

5.4.Энэ бодлогын 5.2-т заасан урт, дунд, богино хугацааны стратегийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон иргэний нийгмийн холбогдох байгууллагууд хамтран хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж, цаашдын хөгжлийн зорилтыг тодорхойлж байх болно.




“Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг соёлын олон төрөл, зүйл дотроос мэдлэг, нэмүү өртгийг шингээх дэвшилтэт техник технологи, инноваци, зохиогчийн эрхэд суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломж, нийгэм, эдийн засгийн үр ашгийг харгалзан дараах хүрээнд хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

“Бүтээлч үйлдвэрлэл”-ийн тодорхойлолт нь соёлын үйлдвэрлэлийн агуулгаас өргөн хүрээтэй, инноваци, технологийн дэвшил, эдийн засгийн өрсөлдөх чадварыг чухалчлан авч үздэг.




“Соёлын үйлдвэрлэл” гэсэн ойлголтын хувьд бүтээлч сэтгэлгээ, хандлагын үүрэг тодорхой харагдахгүй, хамрах хүрээ нь соёлын салбараар хязгаарлагдаж байгаа юм.



Соёлын /бүтээлч/ үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг **i) орон зайн төлөвлөлтөд тулгуурласан:** байдлаар хөгжүүлэх.









Бүтээлч хот болон кластерийг хөгжүүлэх нь шинэ санаа, инновацийг хөгжүүлэх, дэмжих орчин бүрдэх, мөн орон нутгийн соёлын өвөрмөц хэв шинжийг хадгалсан орон зайг бий болгох нь соёлын аялал жуулчлалаар дамжуулан эдийн засгийн үнэ цэнийг бий болгодог.




Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг ii) үйлдвэрлэлийн концепци байдлаар хөгжүүлэх.

Өрсөлдөх чадвартай соёлын агуулга бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь эдийн засгийн үнэ цэнийг бий болгож, улс орнууд олон улсын зах зээлд өрсөлдөх боломж бүрдүүлдэг.



ЮНЕСКО-гийн загварт тулгуурласан Монголын соёлын үйлдвэрлэлийн хамрах хүрээ



СОЁЛЫН ОРОЛЦООГ ХЭМЖИХ


ЮНЕСКО-гийн статистикийн хүрээлэн 2006 онд Европын холбооны “Евробарометр” загварыг хөгжиж буй орнуудын соёлын үйл ажиллагааны нөхцөл байдалд хэрэглэх тухай илтгэлийг бэлтгэж соёлын үйл ажиллагааг дараах 3 ангиллаар тодорхойлсон.




(culture d'apТелевизор үзэх, радио сонсох, хөгжмийн нэвтрүүлэг үзэх ба хөгжим сонсох, ном унших, мөн компьютер болон интернэт ашиглах зэрэгт зарцуулах цаг хугацаатай холбоотой. partement):

(culture de sortie): кинотеатр, театр, концерт, музей, хөшөө дурсгал болон соёлын өвтэй газрууд зэрэг соёлын дурсгалт газруудад очихтой холбоотой.

(culture identitaire) :соёл сонирхогч, соёлын холбооны гишүүнчлэл, түгээмэл соёл, угсаатны соёл, ард түмний дадал болон залуучуудын соёл зэрэг багтана.




СОЁЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭМЖИХ



← Соёлын тоо бүртгэ

СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ ХЭМЖИХ

Соёлын бүтээлч үйлдвэрлэлд ямар салбарууд багтах, үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн бус үйл явцад бүтээгдэх соёлын үйл ажиллагаа, үйлчилгээ, баялгийг яаж хэмжих зэрэг асуудлыг цэгцлэх, олон улсын түвшинд салбарын харьцуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.



-
-
-
-
-
-
-
-
- (Оролцоог хэмжих)
-

АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА.

Г. Батхуяг / Соёл, соёлын өвийн хэлтсийн дарга /
Нэгдсэн үндэстний гудамж 5/1
Засгийн газрын 2 –р байр 123 тоот
И-майл: Batkhuyag@culture.gov.mn
[Цахим хаяг: www.culture.gov.mn](http://www.culture.gov.mn)